



ТӨВ АЙМАГ  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/556

Зуунмод

Газрын дуудлага худалдааны  
орлого хуваарилах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн 04 дүгээр хуралдааны 03 дугаар тогтоолоор батлагдсан “Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журам”-ын 2 дугаар хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд 2022 онд газрын дуудлага худалдаанаас төрийн сангийн газрын биржийн (100140000967) тусгай дансанд орсон орлогыг 2022 оны 06 дугаар сарын 25 аас 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөр тасалбар болгон хуваарилж сумдын нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилах 50 хувийг нэгдүгээр, аймгийн нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилах 40 хувь, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын нэмэлт санхүүжилтийн дансанд хуваарилах 10 хувийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Газрын дуудлага худалдаанаас хуваарилагдсан орлогыг зарцуулахдаа Газрын дуудлага худалдааны орлогыг төвлөрүүлэх, зарцуулах, тайлагнах журмыг баримтлан ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (М.Отгонбат), Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Насанжаргал), холбогдох сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

3.Энэ захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ю.Бямбацогт)-т даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Д.МӨНХБААТАР

Б.Одгоспил.  
Санхүүжилт.  
[Signature]


Аймгийн Засаг даргын 2022 оны  
10 дугаар сарын 04 -ны өдрийн  
А/556 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Газрын дуудлага худалдааны орлогын хуваарь

№	Сумдын нэрс	Газрын дуудлага худалдааны орлого өссөн дүнгээр	Сумдын нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэх 50 хувь /мян.төг/
1	Алтанбулаг	32633.77	16316.9
2	Баян	94175	47087.5
3	Баян-Өнжүүл	800	400.0
4	Баянцогт	358	179.0
5	Баянчандмань	20338.64	10169.3
6	Борнуур	19034.13	9517.1
7	Жаргалант	980.0	490.0
8	Сэргэлэн	690204.56	345102.3
9	Өндөрширээт	19000.0	9500.0
10	Эрдэнэсант	2619.92	1310.0
11	Зуунмод	126767.8	63383.9
	дүн	1006911.8	503455.9

Аймгийн Засаг даргын 2022 оны  
10 дугаар сарын 04 ны өдрийн  
А/556 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Газрын дуудлага худалдааны орлогын хуваарь

№	Сумдын нэрс	Нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэх хувь /%/	Нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлэх дүн /мян.төг/
1	Аймгийн Засаг даргын Тамгын газарт	40	402764.7
2	Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт	10	100691.2
	дүн	50	503455.9

